



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 11 өдөр

Дугаар A/132

Хэрлэн сум

Жендерийн салбар хороог
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.3, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 227 дугаар тогтоолоор баталсан Жендерийн үндэсний хорооны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жендерийн эрх тэгш байдлыг хангах асуудлаар зөвлөх чиг үүрэг бүхий Жендерийн салбар хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр тухайн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогод төсвийн хамт тусгувлан батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, арга зүйгээр ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч бөгөөд жендерийн салбар хэрооны дэд дарга (Л.Батсайхан)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбоодуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/499, 2019 оны А/36 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны

.....**03** дугаар сарын..... ёдрийн

A/132 захирамжийн нэгдүгээр хавсралт

ЖЕНДЭРИЙН САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Салбар хорооны дэд дарга

Засаг даргын орлогч

Гишүүд:

Засаг даргын Тамгын газрын дарга

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн
дарга

Мэргэжлийн хяналтын газрын дарга

Статистикийн хэлтсийн дарга

Цагдаагийн газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Гэр бүл, хүүхэд, запуучуудын хөгжлийн газрын
дарга

Хөдөлмөр, хalamж үйлчилгээний газрын дарга

Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг дахь
төлөөлөл

Дэлхийн зөн Олон Улсын байгууллагын Бор-Өндөр-
2 төслийн ахлагч

Эмэгтэйчүүдийн холбооны төлөөлөл

Хэнтий аймаг дахь Ажил олгогч эздийн холбооны
тэргүүн

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн
танхимын Хэнтий аймгийн салбарын тэргүүн

Нарийн бичгийн
дарга:

Жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2022 оны
...03 дугаар сарын...12 өдрийн
захирамжийн хоёрдугаар хавсралт

A/132

ЖЕНДЭРИЙН САЛБАР ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Жендэрийн үндэсний хорооны аймаг, нийслэл, дүүрэг дэх жендэрийн салбар хороо /цаашид "салбар хороо" гэх/-ны зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Салбар хороо нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, "Жендэрийн үндэсний хорооны дүрэм"-д заасан бүрэн эрхийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллах Жендэрийн үндэсний хорооны зохион байгуулалтын нэгж юм.

1.3. Салбар хороо нь харьяа нутаг дэвсгэртээ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (ЖЭТБХтХ), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөгжлийн бодлого, үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэх, төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалтыг хангаж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

ХОЁР. САЛБАР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1. Салбар хороог Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасны дагуу тухайн шатны Засаг дарга ахалж, түүний үйл ажиллагааг удирдлагаар хангана.

2.2. Салбар хорооны дарга нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4-д зааснаар салбар хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталж мөрдүүлнэ.

2.3. Салбар хороо нь аймгийн ЗДТГ, тэдгээрийн харьяа агентлаг, байгууллага, олон нийтийн байгууллагын оролцоог хангасан байх ба аль нэг хүйсийн төлөөлөл нь 40 хувиас доошгүй байна.

2.4. Салбар хороо нь салбар хорооны дарга /тухайн шатны Засаг дарга/, дэд дарга, нарийн бичгийн дарга /ЗДТГ-ын холбогдох жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн/, гишүүдээс бүрдэнэ.

2.5. Салбар хороо нь сум, хороодод жендэрийн дэд салбар хороодтой байна. Салбар хороо нь дэд салбар хороог мэргэжилт арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана. Дэд салбар хороо нь бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг энэхүү журамд нийцүүлэн боловсруулж, байгууллагын удирдлага (тухайн шатны засаг дарга)-ын шийдвэрээр батлуулж мөрдөнө. Дэд салбар хороо нь салбар хорооны өмнө ажлаа хариуцан тайлagnана.

2.6. Аймаг, салбар хороо нь 13-17, сум, хороод 5-7 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.7. Салбар хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Салбар хорооны хуралдаан (ээлжит)-ыг жилд 4-өөс доошгүй /улирал тутам/ удаа хийнэ. Хуралдааныг салбар хорооны дарга удирдана.

2.8. Шаардлагатай тохиолдолд салбар хорооны ээлжит бус хуралдааныг салбар хорооны даргын санаачилгаар, эсхүл хорооны гишүүдийн олонхийн санаачилгаар зарлан хуралдуулж болно. Гишүүдийн 50-иас дээш хувь нь хуралдаанд ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.9. Салбар хорооны хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

2.10. Салбар хороо нь хуралдааны дэгээ энэ журамд нийцүүлэн өөрөө тогтооно.

2.11. Салбар хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлаар салбар хорооны дарга (Засаг даргын) захирамж, хурлын тэмдэглэл гарна.

2.12. Салбар хорооны хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, дарга хянаж гарын үсэг зурж албажуулна.

ГУРАВ. САЛБАР ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГ

3.1. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх хүрээнд:

3.1.1. Орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, шийдвэрт жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тусгах замаар хөгжлийн бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох;

3.1.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төсөлтэй уялдуулан хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд тухайн шатны ИТХ-д танилцуулах, шийдвэрлүүлэх;

3.1.3. Холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг салбар хороодын гишүүн байгууллагуудын жилийн төлөвлөгөөнд шаардагдах төсвийн хамт тусгувалж, тухайн оны эхний улиралд багтаан батлуулан Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх;

3.1.4. Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, биелэлтэд хяналт тавьж ажиллах;

3.1.5. Бүх шатны Засаг дарга нартай байгуулах гэрээ болон холбогдох төрийн байгууллагуудын удирдлагуудтай хийх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ЖЭТБХтХ, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тусгах, үр дүнг тооцох;

3.1.6. Төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах, хэрэгжилтийг тайлагнах;

3.1.7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар, чиглэл, арга зүйн зөвлөгөө өгөх;

3.1.8. Салбар, орон нутгийн байгууллага болон төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа дэмжих, салбар дундын зохицуулалтыг хангах;

3.1.9. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан холбогдох тайлан мэдээг бэлтгэж, тогтоосон хугацаанд Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх;

3.2. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийж хүрээнд:

3.2.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих ажлыг харьяалах байгууллага, орон нутгийн хэмжээнд /сум, хороо/ зохион байгуулах;

3.2.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцоонд сууринсан аргачгалаар хяналт шинжилгээ, үнэлгээг жил

бүр, хууль тогтоомжид заасан хугацаанд хөндлөнгийн үнэлгээг холбогдох ТББ-аар тус тус хийж гүйцэтгүүлэх;

3.1.3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилт болон тухайн орон нутагт жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ зэрэг хийхэд энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагуудаар гүйцэтгүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.1.4. Холбогдох хууль тогтоомж, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэх;

3.1.5. Салбар хорооны гишүүдийн жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд ЖЭТБХтХ, холбогдох, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг шалгуур үзүүлэлтийн хамт тусгах, үр дүнг тооцох;

3.3. Жендэр статистик мэдээллийг бүрдүүлэх хүрээнд:

3.3.1. Тухайн орон нутаг, салбарын хэмжээнд хүйсээр ангилсан статистик мэдээллийг бүрдүүлэх;

3.3.2. Орон нутгийн жендэрийн нөхцөл байдлын статистик мэдээлэл /үзүүлэлт/-ийг бүрдүүлэх, цаашид тус үзүүлэлтүүдийг сайжруулан жил бүр тогтмол гаргаж хэвшүүлэх;

3.3.3. Хүйсээр ангилсан статистикийн мэдээлэлд үндэслэн жендэрийн эрх тэгш байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх, үнэлгээнд үндэслэн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах;

3.3.4. Хүйсээр ангилсан мэдээллийг эмхэтгэн, хэрэглэгчдэд хүргэх, түүнийг бодлого боловсруулахад ашиглахад чадавхжуулах арга хэмжээг зохион байгуулах;

3.3.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8, 19.1.9-д заасан тайлан, мэдээг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

3.4. Жендэрийн сургалт, судалгаа, гэгээрлийн ажлын хүрээнд:

3.4.1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай орон нутгийн чадавхыг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэх; щ

3.4.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой сайн туршлагыг аж ахуйн нэгж байгууллага, олон нийтэд таниулан сурталчлах;

3.4.3. Жендэрийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх гэгээрэл, сурталчилгааны ажлыг хүн амын дунд зохион байгуулахад арга зүйн дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

3.4.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалахад олон нийтийн болон хувийн хэвшилийн байгууллага, ОУ-ын байгууллага, иргэдийн оролцоог хангаж, үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах; щ

3.4.5. Жендэрийн үндэсний хорооны цахим хуудаст байршил “Удирдах албан тушаалтнуудад зориулсан жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх жендэрийн цахим сургалт”-д хамрагдаж, гэрчилгээ авах;

3.5. Жендэрийн ялгavarлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр:

3.5.1. Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгavarлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоо чиглэлээрх холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хамтын ажиллагаа, чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.5.2. Орон нутгийн түвшинд анхан шатны нэгжүүдэд жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, жендэрийн ялгavarлан гадуурхалтад өртсөн

тохиолдолд зөвлөн туслах, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагааны зардлыг шийдвэрлүүлэх;

3.5.3. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх нэг цэгийн үйлчилгээг үзүүлэхэд төр, ИНБ-удын хамтын ажиллагааг бэхжүүлэх, хамtran аижллах;

3.5.4. Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнд орон нутгийн иргэд, олон нийт залуучууд, зорилтот бүлгийн оролцоог хангах;

3.5.5. Гэр бүл, нийгэм, соёлын харилцаанд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг арилгах, өөрчлөх талаар бүх нийтийн жендерийн боловсролыг дээшлүүлэх сургалт, гэгээрлийн аяныг өрнүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.5.6. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлогын хүрээнд эрэгтэй эмэгтэй хүний нийгэм, гэр булийн харилцаанд үүссэн тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн түр тусгай арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах;

3.6. Улс төрийн хүрээнд дэх жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

3.6.1.Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхуулах арга хэмжээг орон нутгийн хэмжээнд тогтмол зохион байгуулах, энэ чиглэлээр хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэх;

3.6.2.Улс төр, төрийн алба, бизнес, иргэний нийгмийн байгууллагуудтай залуу манлайлагч эмэгтэйчүүдийг бэлтгэх, сургалт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамtran ажиллах;

3.7.Эдийн засгийн хүрээнд дэх жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

3.7.1. Тухайн орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслийг жендерийн мэдрэмжтэй төлөвлөх, төсөвлөх арга зүйг нэвтрүүлэх;

3.7.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон төрөөс үзүүлж, байгаа бүх төрлийн үйлчилгээг жендерийн мэдрэмжтэй болгох арга зүйн дэмжлэг үзүүлэх;

3.7.3.Охид, эмэгтэйчүүд, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ажилтан, албан хаагчид)-ийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, хөнгөлөлттэй зээл, тусlamж үзүүлэх хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэх;

3.8. Төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангах хүрээнд:

3.8.1.ЖЭТБХТХ-ийн 10 дугаар зүйлд заасан төрийн албан дахь жендерийн эрх тэгш байдлын баталгааг хангаж, төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албандаа орох, албан тушаал, эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр шаардлагатай зөвлөмж, дүгнэлтийг гаргаж, хэрэгжилтийг хангуйж ажиллах;

3.8.2.Төрийн албыг жендерийн ялгаралтан гадуурхалтаас ангид байлгах, эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгохгүй байх, тодорхой салбар, нэгж дэх хүйсийн тэнцвэргүй байдлыг арилгах арга хэмжээ (түр тусгай арга хэмжээ) авах хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

3.8.3.Төрийн байгууллагын дэргэдэх хороо, зөвлөл, комиссын бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэрт байдлыг хангуулах, хэрэгжилтийг тайлагнах;

3.9. Хөдөлмөр, эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

3.9.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааг жендерийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйл (Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгын 7 дугаар зүйлд заасан дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох, түүнээс урьдчилан сэргийлэх)-д заасан ажил олгогчийн үүргийн хэрэгжилтийг харьяа байгууллага, нутаг дэвсгэрийн хүрээнд хангуулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.9.2.Хүүхэд төрүүлэх, хүүхэд асрах чөлөө авсан ажилтны мэргэжил, мэргэшлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөж, чадауйц түвшинд байлгах зорилгоор тэднийг давтан сургалтад хамруулах бодлогыг байгууллага, харьяа агентлаг, нутаг дэвсгэрийн хэмжээнд авч хэрэгжүүлэх;

3.9.3. Ажлын байранд бэлгийн дарамт гараахаас урьдчилан сэргийлэх, бэлгийн дарамтыг үл тэвчих орчныг бүрдүүлэх, гарсан гомдлыг шийдвэрлэх хэм хэмжээг хөдөлмөрийн дотоод журамд тусгуулах ажлыг байгууллага, харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих;

3.9.4.Байгууллагын түвшинд жендерийн мэдрэмжтэй байгууллагын соёл, ажил ар гэр, амьдралын тэнцвэрт байдлыг хангах, гэр булийн үүргээ хослуулах, эрүүл мэндээ хамгаалах, хөдөлмөрийн аюулгүй, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, ажлын уян хатан цагийн зохицуулалтыг хийхэд арга зүйн зөвлөгөө өгөх;

3.10. Соёл, боловсрол дахь жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

3.10.1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллага зэрэг зарим байгууллагын ажил, үйлчилгээний онцлогоос хамаарч түр, тусгай арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.10.2.Сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, шалгуур үзүүлэлтэд жендерийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг тусгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.10.3.Эрүүл мэнд, нөхөн үржихүйн боловсрол олгох хичээлийн агуулгыг насын онцлогт тохируулан ЕБС болон агбан сургалт, их дээд сургуулийн хөтөлбөрт тусгуулах;

3.11.Эрүүл мэндийн салбар дахь жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр:

3.11.1. Эрэгтэй, эмэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс (эрэгтэй, эмэгтэй)-ийн эрүүл мэндийн онцлог хэрэгцээнд зориулсан үйлчилгээг бий болгоход чиглэсэн арга хэмжээг авах, үйл ажиллагааг тогтвортойгоор дэмжих;

3.11.2.Орон нутгийн алслагдмал нутгийн хүн ам, малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, явуулын эрүүл мэндийн үйлчилгээг тогтмол хүргэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.11.3.Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нөхөн үржихүй болон эрүүл мэндийн чиглэлээр насын онцлогт тохируулан мэдрэлгээний олгоход дэмжлэг үзүүлэх;

3.12.Жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хувийн хэвшил, олон нийтийн байгууллагын оролцоог хангах чиглэлээр: